



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 23-өдөр

Дугаар A/203

Мандалговь

Г Улсын нөөцийн хашаанд цооног өрөмдөх  
ажил хүлээлцэх комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Улсын нөөцийн хашаанд цооног өрөмдөх ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга: Б.Төвшинжаргал (Онцгой байдлын газрын нягтлан бодогч)

Гишүүд: Б.Цэрэнсугир (Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлэг үргжлийн албаны дарга)

Т.Эрдэнэ (“Грандхолдинг” ХХК-ийн инженер)

Хоёр. Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Д.Энхтуяа)-д даалгасугай.



482060825